

ХҮНДЭТ ДОКТОР ЦОЛ ОЛГОВ

- 2013 оны 8 дугаар сарын 20-ны өдөр Кембрижийн их сургуулийн Монгол, Өвөр Ази судлалын төвийн судлаач, доктор Урадын Э. Булагт ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэнгийн “Хүндэт доктор” цол олгох ёслолын ажиллагаа боллоо. Ёслолын ажиллагааны дараа Олон улс судлалын хүрээлэнгийн хүндэт доктор Урадын Э.Булаг “Хятад дахь үндэстний бүс нутгийн өөртөө засах байгуулал, түүнийг аюулгүйжүүлэх нь: нэг зүйлийн харилцан сэргэлцэх улс төрийн тогтолцооны талаархи дүн шинжилгээ” сэдэвт лекц уншлаа. Уг арга хэмжээнд ШУА-ийн Ерөнхийлөгч Б.Энхтүвшин, дэд ерөнхийлөгч Д.Дорж, ГХЯ-ны Хөрш орон судлалын газар, Стратеги судлалын хүрээлэн, ФСЭЗХ, Олон улс судлалын хүрээлэнгийн захирлын үүрэг гүйцэтгэгч Д.Шүрхүү болон хүрээлэнгийн ажилтнууд, МУИС, ХИС-ийн багш, оюутнууд, Монцамэ агентлаг болон хэвлэл мэдээллийн төлөөлөгчид оролцлоо.

- ОХУ-ын ШУА-ийн Дорно дахины судлалын хүрээлэнгийн Монгол судлалын секторын эрхлэгч, доктор В.В.Грайворонскийд Оросын монгол судлал, Монголын түүхийн судлалд оруулсан хувь нэмрийг нь үнэлэн Олон улс судлалын хүрээлэнгийн “Хүндэт доктор” цол хүртээх ёслолын ажиллагаа 2013 оны 10-р сарын 2-ны 10.00 цагт ШУА-ийн Хүрээлэнгүүдийн нэгдсэн II байрны хурлын танхимд болов. Ёслолын үйл ажиллагаанд Монгол Улсын ШУА-ийн Ерөнхийлөгч Б.Энхтүвшин, дэд ерөнхийлөгч Д.Дорж, ОХУ-аас Монгол улсад суугаа ЭСЯ-ны хэвлэл мэдээллийн атташе А.С.Акулова болон бусад ажилтнууд, ОХУ-ын ШУА-ийн Дорно дахины хүрээлэнгийн солонгос, монгол судлалын секторын дарга А.В.Воронцов, монгол судлаач эрдэмтэн, доктор Е.В.Бойкова, Олон улс судлалын хүрээлэнгийн захирлын үүрэг гүйцэтгэгч Д.Шүрхүү болон тус хүрээлэнгийн эрдэмтэн судлаачид, хэвлэлийн мэдээллийн төлөөлөгчид оролцлоо. Уг ёслолын ажиллагааны дараа Олон судлалын хүрээлэнгийн хүндэт доктор В.В.Грайворонский “Орчин үеийн орос-монголын харилцааны тулгамдсан асуудлууд” сэдвээр лекц уншлаа. Энэ үеэр ОХУ-ын ШУА-ийн Дорно дахины хүрээлэнгээс гадаадын эрдэмтэн, судлаачдад олгодог “Крачковскийн медаль”-ийг тус хүрээлэнгийн зөвлөх, доктор, профессор Л.Хайсандайд олгосныг тус хүрээлэнгийн Солонгос, Монгол судлалын секторын дарга А.В.Воронцов гардуулсан байна.

Мэдээ бэлтгэсэн А.Нямдолжин
/ОУСХ-гийн эрдэмтэн нарийн бичгийн дарга/